ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2026/016/НА-СТА-ТТЗ**

**ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Зуунмод 2026 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитор Б.Нямсүрэн
Утас: 70272248 Цахим хаяг: nyamsurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2026.03.24 № 01/253

танай ______________-ны № ____________________-т

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Я.ЭНХБААТАР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх нийт 351,898.1 мянган төгрөгийн төсөвтэй нийт 5 ажил үйлчилгээнээс ТӨААРСЗДТГ/20250202020 тендерийн дугаартай Гудамж талбай өнгө үзэмж засаж сайжруулах ажилд 250,000.0 мянган төгрөгийн ажил 71% -ийн гүйцэтгэлтэй байна. Нийтийн биеийн тамирын талбай 146,300.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгэл нь дуусаж ажил хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Сумын орлогын төлөвлөгөөгөөр улс, аймаг, сумын 3 шатанд 2025 оны жилийн эцсээр 1,179,224.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1,791,851.6 мянган төгрөгийг төвлөрүүлж биелэлт 151,9 хувьтай байна. Нийт 19 нэр төрлийн орлого төлөвлөснөөс 3 төрлийн орлого 5,937.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус сумын 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд 12 хөтөлбөр, 121 арга хэмжээг хэрэгжүүлж 89,2 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4126020629

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

**/мянган төгрөгөөр/**

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 1,515,226.52 | 1,883,003.08 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 889,220.51 | 1,021,959.95 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 480,620.09 | 660,531.3 |
| 4 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 145,385.92 | 200,511.83 |
| 5 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 2,624,096.04 | 2,958,583.57 |
| 6 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 2,624,096.04 | 2,958,583.57 |
| 7 | 1.2.2.02 Биет хөрөнгө | | 1,965,002.88 | 2,296,322.97 |
| 8 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 13 | 659,093.17 | 662,260.6 |
| 9 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | | 4,139,322.57 | 4,841,586.65 |
| 10 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 148.68 | 56,297.89 |
| 11 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 148.68 | 56,297.89 |
| 12 | 2.1.1.03 Өглөг | | 148.68 | 56,297.89 |
| 13 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 4,139,173.89 | 4,785,288.75 |
| 14 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | | 4,139,173.89 | 4,785,288.75 |
| 15 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | | 1,385,745.21 | 1,385,745.21 |
| 16 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | | 2,610,956.88 | 3,257,071.74 |
| 17 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 142,471.8 | 142,471.8 |
| 18 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | | 4,139,322.57 | 4,841,586.65 |

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

**/мянган төгрөгөөр/**

| № | Дансны нэр, төрөл | Тодруулга | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | 2,242,773.19 | 2,952,720.68 |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | | 942,168.89 | 1,340,236.08 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | | 668,490.43 | 785,682.81 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | | 668,490.43 | 785,682.81 |
| 5 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | | 133,639.77 | 157,730.73 |
| 6 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | | 140,038.68 | 396,822.55 |
| 7 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 530,897.76 | 1,612,484.6 |
| 8 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | | 0.0 | 1,013,439.94 |
| 9 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 769,706.54 | 0.0 |
| 10 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 1,766,290.83 | 2,305,618.92 |
| 11 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,662,287.11 | 2,029,852.38 |
| 12 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,626,982.71 | 1,957,989.1 |
| 13 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 678,070.21 | 792,301.28 |
| 14 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 84,090.47 | 102,104.1 |
| 15 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 420,677.67 | 545,983.67 |
| 16 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | | 50,812.72 | 38,924.13 |
| 17 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | | 103,476.46 | 124,230.73 |
| 18 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | | 12,722 | 15,837.5 |
| 19 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | | 6,422 | 3,848 |
| 20 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 5,158.36 | 16,748.67 |
| 21 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | | 265,552.83 | 318,011.01 |
| 22 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 35,304.4 | 71,863.28 |
| 23 | 1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 104,003.72 | 275,766.54 |
| 24 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 476,482.36 | 647,101.76 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 25 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 782 | 986.9 |
| 26 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | | -782 | -986.9 |
| 27 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | | 475,700.36 | 646,114.86 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/мянган төгрөгөөр/**

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,094,712.48 | 3,003,104.51 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 942,168.89 | 1,340,236.08 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 668,490.43 | 785,682.81 |
| 4 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 133,639.77 | 157,730.73 |
| 5 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 140,038.68 | 396,822.55 |
| 6 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 6,973.39 | 10,318.98 |
| 7 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 133,065.29 | 383,893.31 |
| 8 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 0.0 | 2,610.26 |
| 9 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 382,837.06 | 1,662,868.42 |
| 10 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 382,837.06 | 507,796.68 |
| 11 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 1,013,439.94 |
| 12 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 141,631.8 |
| 13 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 769,706.54 | 0.0 |
| 14 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,533,816.22 | 2,042,014.04 |
| 15 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 1,533,816.22 | 2,042,014.04 |
| 16 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,497,328.93 | 1,968,777.52 |
| 17 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 677,253.56 | 787,249.51 |
| 18 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,198.25 | 98,896.11 |
| 19 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 422,040.24 | 545,896.77 |
| 20 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 30,743.89 | 32,083.24 |
| 21 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 127,220.85 | 125,448.08 |
| 22 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 19,403.05 | 224,614.27 |
| 23 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 6,422 | 3,848 |
| 24 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,303.58 | 41,540.08 |

| | | | |
|---|---|---|---|
| 25 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 120,743.51 | 109,201.46 |
| 26 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 36,487.3 | 73,236.52 |
| 27 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 560,896.25 | 961,090.47 |
| 28 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 275,718.85 | 643,192.93 |
| 29 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 275,718.85 | 643,192.93 |
| 30 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 275,718.85 | 643,192.93 |
| 31 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -275,718.85 | -643,192.93 |
| 32 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 782 | 141,060.1 |
| 33 | 1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 0.0 | 44,098 |
| 34 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -782 | -185,158.1 |
| 35 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 284,395.41 | 132,739.44 |
| 36 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 604,825.11 | 889,220.51 |
| 37 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 889,220.51 | 1,021,959.95 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/мянган төгрөгөөр/**

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,659,917.81 | | 3,659,917.81 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,555.72 | | 3,555.72 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,663,473.54 | | 3,663,473.54 |
| 4 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 475,700.36 | | 475,700.36 |
| 5 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,139,173.89 | | 4,139,173.89 |
| 6 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,139,173.89 | | 4,139,173.89 |
| 7 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,139,173.89 | | 4,139,173.89 |
| 8 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 646,114.86 | | 646,114.86 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,785,288.75 | | 4,785,288.75 |

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/мянган төгрөгөөр/**

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 3,356,517.10 | 3,729,226.43 | 372,709.33 | 111.10% |
| 11 | 3.1.01.1.1 Татварын орлого | 989,736.40 | 1,340,236.08 | 350,499.68 | 135.41% |
| 110 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 723,513.70 | 785,682.81 | 62,169.11 | 108.59% |
| 1100 | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 723,513.70 | 785,682.81 | 62,169.11 | 108.59% |
| 113 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 120,680.00 | 157,730.73 | 37,050.73 | 130.70% |
| 118 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 145,542.70 | 396,822.55 | 251,279.85 | 272.65% |
| 1180 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 6,000.00 | 10,318.98 | 4,318.98 | 171.98% |
| 1181 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 139,542.70 | 383,893.31 | 244,350.61 | 275.11% |
| 1182 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | - | 2,610.26 | 2,610.26 | |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 2,366,780.70 | 2,388,990.34 | 22,209.64 | 100.94% |
| 120 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 280,000.00 | 367,165.21 | 87,165.21 | 131.13% |
| 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 1,944,072.00 | 1,880,193.33 | (63,878.67) | 96.71% |
| 123 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 142,708.70 | 141,631.80 | (1,076.90) | 99.25% |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,532,323.10 | 3,813,238.55 | 1,280,915.45 | 150.58% |
| 21 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 1,983,067.20 | 3,485,289.45 | 1,502,222.25 | 175.75% |
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,907,037.20 | 1,724,162.73 | (182,874.47) | 90.41% |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 711,494.80 | 702,390.82 | (9,103.98) | 98.72% |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 89,148.90 | 88,630.21 | (518.69) | 99.42% |
| 2103 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 548,643.50 | 545,896.77 | (2,746.73) | 99.50% |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 40,105.50 | 24,378.61 | (15,726.89) | 60.79% |
| 2105 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 1,690.00 | 1,420.00 | (270.00) | 84.02% |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 292,800.00 | 224,047.77 | (68,752.23) | 76.52% |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 8,500.00 | 3,848.00 | (4,652.00) | 45.27% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 118,157.00 | 41,154.08 | (77,002.92) | 34.83% |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 96,497.50 | 92,396.46 | (4,101.04) | 95.75% |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 76,030.00 | 1,761,126.73 | 1,685,096.73 | 2316.36% |
| 2131 | 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | 1,687,890.20 | 1,687,890.20 | |
| 2132 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 76,030.00 | 73,236.52 | (2,793.48) | 96.33% |
| 22 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 369,255.90 | 186,889.00 | (182,366.90) | 50.61% |
| 23 | 3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 180,000.00 | 141,060.10 | (38,939.90) | 78.37% |
| 8 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 824,194.00 | (84,012.13) | (908,206.13) | -10.19% |
| 9 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (824,194.00) | 84,012.13 | 908,206.13 | -10.19% |
| 7 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (824,194.00) | 84,012.13 | 908,206.13 | -10.19% |
| 4 | 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 879,419.94 | 879,419.94 | |
| 5 | 5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 998,462.97 | 998,462.97 | |
| 6 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 58 | 58 | - | 100.00% |
| 61 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | - | 100.00% |
| 62 | 6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО | 28 | 28 | - | 100.00% |
| 65 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 28 | 28 | - | 100.00% |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 265,838.30 | 586,272.14 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 265,838.30 | 574,368.18 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 265,838.30 | 118,064.25 |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 193,561.00 | 118,064.25 |
| 2101 | 1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 74,851.00 | 83,081.03 |
| 2102 | 1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,249.00 | 10,265.90 |
| 2104 | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 4,082.10 | 7,345.82 |
| 2106 | 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | | 566.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 2109 | 1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 103,996.80 | 16,805.00 |
| 22 | 1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 265,838.30 | 456,303.93 |
| 2200 | 1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр | 265,838.30 | 456,303.93 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Залруулагдаагүй нийт 6,297.3 мянган төгрөгийн зөрчлөөс 6,297.3 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 17,929.6 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт өгөгдөөгүй.

### 5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл татварын албанаас ирүүлсэн гүйцэтгэлийн мэдээтэй 359.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил бүтэн жилээр бэлтгэж тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Татварын болон татварын бус орлогын мэдээг үнэн зөв мэдээлж буй эсэхэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

2. Орлогын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Сумын орлогын төлөвлөгөөгөөр улс, аймаг, сумын 3 шатанд 2025 оны жилийн эцсээр 1,179,224.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 1,791,851.6 мянган төгрөгийг төвлөрүүлж биелэлт 151,9 хувьтай байна. Нийт 19 нэр төрлийн орлого төлөвлөснөөс 3 төрлийн орлого 5,937.4 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд хангаан биелүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 3 | 15,221.6 | | | 1 | 4,814.0 | 2 | 10,407.6 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 17,252.3 | | | | | 1 | 17,252.3 |
| Эргэлтийн эмийн сан | 2 | 57,533.4 | | | 1 | 57,533.4 | 1 | - |
| ИТХ | 1 | - | | | | | 1 | - |
| Засаг дарга | 2 | 6,297.3 | | | | | 2 | 6,297.3 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 1 | 1,024.9 | | | | | 1 | 1,024.9 |
| **Дүн** | **10** | **97,329.5** | | | **2** | **62,347.4** | **8** | **34,982.1** |

## Тав. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Тувээрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | | 1 | | | | | |
| 2 | Засаг даргын тамгын газар | 1 | 1 | | | 1 | | | |
| 3 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Эмийн эргэлтийн сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | **5** | **1** | **4** | | **1** | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn